



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 548

Хэрлэн сум

Цалин шинэчлэн тогтоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2, 57.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 194 дүгээр тогтоол, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт батлах тухай” 274 дүгээр тогтоол, Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтад өөрчлөлт оруулсантай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын зарим албан хаагчдын цалинг хавсралтад зааснаар шинэчлэн тогтоосугай.

2. Шинэчилсэн цалинг 2022 оны 6 дугаар сарын 01-ээс тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.


3. Албан хаагчдын зэрэглэл өөрчлөгдсөнтэй холбоотойгоор хуулийн үйлчлэлд хамаарах албан хаагчийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030310



Аймгийн Засаг даргын Тамгын газрын цалин шинэчлэн тогтоох зарим албан
хаагчдын жагсаалт

№	Албан хаагчийн нэр	Хэлтсийн нэр	Албан тушаал	Өмнөх ангилал, зэрэглэл, шатлал	Шинэчилсэн ангилал зэрэглэл, шатлал
1	Д.Цэцэгсүрэн	Санхүү төрийн сангийн хэлтэс	Төсвийн ерөнхий нягтлан бодогч	T3-6-5	T3-8-5
2	Х.Баярбаатар	Санхүү төрийн сангийн хэлтэс	Төвсийн орлого, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн	T3-5-2	T3-7-2
3	М.Дэлгэрзаяа	Санхүү төрийн сангийн хэлтэс	Төсвийн зарлага хариуцсан мэргэжилтэн	T3-5-2	T3-7-2
4	Б.Цэцэгмаа	Санхүү төрийн сангийн хэлтэс	Ахлах, Бүртгэлийн мэргэжилтэн	T3-6-5	T3-7-5
5	Б.Онончимэг	Санхүү төрийн сангийн хэлтэс	Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн	T3-5-5	T3-7-5
6	Б.Хулан	Санхүү төрийн сангийн хэлтэс	Төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн	T3-5-1	T3-6-1
7	Д.Бадамцэцэг	Санхүү төрийн сангийн хэлтэс	Төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн	T3-5-2	T3-6-2